


4 Page




5 Page



6 Page



7 Page



8 Page

БҮТЭЭЛ

-The Creation-

Тайлбарлагч Бүхний эхэнд дэлхий ертөнц харанхуй хоосон, юу ч байхгүй байлаа.

Зөвхөн Эзэн Бурхан л оршиж байв. Хайр дүүрэн Эзэн Бурхан дэлхийг маш гоё болгохыг хүсчээ. Тэгээд нэгэн өдөр, Эзэн Бурхан ингэж айлджээ.

Бурхан “Гэрэл бий болог!”

Тайлбарлагч Бурханы хэлсний дагуу нүд гялбам гэрэл дэлхийг гэрэлтүүлэн гийгүүлжээ. Тэр гэрлийг Бурхан хараад сайхан байна гэв. Бурхан гэрлийг “өдөр” гэж, харин харанхуйг “шөнө” гэж нэрлэв. Тэр нь анхны өдөр болой. Хоёр дахь өдөр нь Бурхан дахин айлдлаа.

Бурхан “Тэнгэр ба ус бий болог!”

Тайлбарлагч Түүний хэлснээр тэнгэр ба ус бий болгогджээ. Тэнгэр ба газрыг харахад маш үзэсгэлэнтэй байлаа. Гурав дахь өдөр Бурхан газар дээрх усыг нэг дор хуримтлуулан хуурай газрыг ил гаргав.

Бурхан “Ус байхгүйг хуурай газар, хуримтлагдсан усыг далай гэж нэрлэе!”

Тайлбарлагч Тэгээд Бурхан – газар дэлхий нялх ногоо, үрт ургамал, үрт жимсний модыг төрөл төрлөөр нь ургуула! Гэсэнд тэр нь хэлсэн ёсоор болов. Анхилам үнэртэй сайхан цэцэгс дэлгэрч, нов ногоон модод ургахыг хараад Түүнд сайхан байлаа. Ингээд газар дэлхий үзэсгэлэнтэй сайхнаар бүтээгдэв. Дөрөв дэхь өдөр Эзэн Бурхан ингэж айлджээ.

Бурхан “Тэнгэрт нар, сар ба одод бий болог!”

Тайлбарлагч Түүний хэлснээр өдөр нь нар тэнгэрт гэрэлтэж бүх ертөнцийг гэрэлтүүлэн, шөнө нь сар ба одод үзэсгэлэнтэйгээр гялалзаж байлаа. Энэ бүгдийг харахад Бурханд сайхан байлаа. Тав дахь өдөр, Бурхан айлдсан нь :

Бурхан “Тэнгэрт дүүлэн нисэх шувууд ба далайд сэлэн амьдрах загаснууд бий болог!”

Тайлбарлагч Түүнийг ийнхүү айлдахад, хөөрхөн шувууд тэнгэрт нисэлдэж, гол ба нуур, далайд өхөөрдөм загаснууд сэлэлдэж эхлэв. Зургаа дахь өдөр, Бурхан газар дээр амьдрах амьтдыг бүтээжээ.



9 Page

Бурхан “Газар дээр амьтад бий болог!”

Тайлбарлагч Түүнийг ийнхүү айлдахад төрөл бүрийн араатан амьтад бий болжээ. Том биетэй хүчтэй заан, жижигхэн өхөөрдөм туулай, аймшиггүй бар гээд л төрөл бүрийн дүр төрхтэй янз бүрийн амьтад бий болж Бурханыг магтацгаав. Бурхан ихэд баяртай байв.

.....

Тайлбарлагч Эзэн Бурхан хамгийн сүүлд Өөрийнхөө дүр төрхийн дагуу хүнийг бүтээжээ. Бурхан шороогоор хүнийг бүтээж, хүний хамарт нь амийн амьсгалыг үлээн хийв. Тэгээд хүн амьтай болжээ. Тэр анхны хүнийг “Адам” гэж нэрлэжээ. Бурхан Адамд ингэж айлдав.

Бурхан “Өсөн нэмэгдэж, өнөр өтгөн болж, газар дэлхийг дүүргэн, газрыг эзэмш! Далайн загас, огторгуйн шувууд хийгээд газар дэлхий дээр хөдөлдөг бүх амьтдыг захир хэмээн айлдав.”

Тайлбарлагч Долоо дахь өдөр болмогц Эзэн Бурхан хийж бүтээсэн бүх ажлаа дуусгаж амрав. Тэгээд тэр амарсан өдрөө ерөөж, ариун болгожээ. Тиймээс Бурханд итгэдэг хүмүүс долоо дахь өдөр амарцгааж Бурханд алдар магтаалыг өргөдөг болсон билээ.